# ЭМ ЖИ ЭЛ АКУА ХК-ИЙН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

| Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/ | |
|---|---|
| *Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.* | |
| | |
| *Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/* | 2024.01.01-ний өдрөөс<br>2024.12.31-ний өдөр |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | Эм Жи Эл Акуа ХК<br>УБГ: 9007001026<br>Үнэт цаасны код: MGLA<br>Утасны дугаар: 77045555 |
| *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | Монголын хөрөнгийн бирж |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | Хүнсний худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ |
| *Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо* | Пи Кэй Эф Ай Эй Эс аудит ХХК<br>7071297 |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | 327,555,616 ширхэг хувьцаа олон нийтэд |
| *Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр* | Ерөнхий нягтлан бодогч: Д.Бат-Ирээдүй |

| | | |
|---|---|---|
| | | |
| *1.* | *Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/* | |
| | *Санхүүгийн байдлын үзүүлэлт* | **Тайлан хавсаргасан** |
| | *Орлогын тайлан* | **Тайлан хавсаргасан** |
| | *Өмчийн өөрчлөлтийн тайлан* | **Тайлан хавсаргасан** |
| | *Мөнгөн гүйлгээний тайлан* | **Тайлан хавсаргасан** |
| | | |
| *1.1.* | *Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт* | |

| | | |
|---|---|---|
| | 2024 оны жилийн эцсийн тайлан Пи Кэй Эф Ай Эй Эс аудит ХХК-р хянуулж батлуулахаар гэрээ хийж ажиллаж байна. | |
| *1.2.* | *Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/* | |
| | Аудит бүтэн жилээр хийгдэхээр 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан тул жилийн тайланд аудитын тодорхойлох захидлыг хавсаргана. | |
| *2.* | *Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл* | |
| *2.1.* | *Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/* | Санхүүгийн үзүүлэлтүүд<br>**Ашигт ажиллагаа** |
| *2.2.* | *Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт* | Нийт хөрөнгийн өгөөж (ROA) 7%<br>Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 8%<br>Ханш, бүртгэлийн үнийн харьцаа (P/B) 1.5<br>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (EPS) 10.39<br>Хувьцааны үн ба ашиг харьцаа (PE) 17.6<br>2024 онд нэгж хувьцаанд хуваарилах ноогдол ашиг 7.31 |
| *2.3.* | *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл* | Эм Жи Эл Акуа ХК нь 2024 онд усны зах зээлийн зах зээлийн 40%-г хамарсан. |
| *2.4.* | *Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/* | Санхүү байдлын тайлангаас гадуурх бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй. |
| *2.5.* | *Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;* | Байхгүй |
| *3.* | *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/* | |

| | |
|---|---|
| | Байхгүй |
| *4.* | *Цалин урамшууллын мэдээлэл* |
| | Компанийн 2024 оны нийт цалингийн зардал 5.8 тэрбум, өмнөх онтой харьцуулахад 52%-иар өссөн. Энэ нь орон тооны өсөлт болон дундаж цалингийн өсөлт 33% юм.<br>2024 онд компани хувьцаат компани болсонтой холбоотой ТУЗ-д 258 сая төгрөгийн цалингийн зардал зарцуулсан байна. |
| *5.* | *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл* |
| | Эм Жи Эл Акуа ХК-ийн шинээр бүрэлдсэн ТУЗ нь танхимаар 5, цахимаар 3 удаа нийт 8 удаа хуралдсан. Тус хурлуудаар компанийн засаглалын журмууд, охин компани байгуулах, Өмнөговь аймагт байгуулах үйлдвэрийн газар худалдан авах зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн.<br><br>2024 оны 11 сард ТУЗ-ийн дэргэдэх Аудит эрсдэлийн хорооноос менежментийн багт эрсдэлийн үнэлгээний болон Борлуулалтын орлогын төсөөллийг тооцох аргачлалын талаар сургалтыг оров. Мөн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооноос менежментийн багт компанийн засаглалын талаарх сургалтыг 10, 11 саруудад 2 удаа зохион байгуулав.<br><br>2024 оны 10 сарын 16-нд ТУЗ-ийн Стратеги бизнес хөгжлийн хорооноос 2025 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэж санал зөвлөмжийг менежментийн багт хүргүүлэв.<br><br>Компанийн Хөрөнгө оруулагчдын харилцааны хорооноос хувьцаа эзэмшигчдээс ирсэн санал хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэв.<br><br>Компани 6 сард нэгж хувьцааг 174 төгрөгөөр олон нийтэд санал болгосон бөгөөд 2025.02.21-ний өдрийн байдлаар компанийн хувьцааны ханш 175.9 төгрөг байна. |
| *6.* | *Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл* |
| | Байхгүй. |
| *7.* | *Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/* |
| | Байхүй |
| *8.* | *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл* |
| | Эм Жи Эл Акуа ХК нь IPO-р татан төвлөрүүлсэн хөрөнгийг дунд хугацааны бизнес төлөвлөгөөний зорилтоо хэрэгжүүлэх ажлын хүрээнд зарцуулахаар төлөвлөсөн.<br>Компани 2024 оны 5-р сарын 31-ний өдөр IPO-оор татан төвлөрүүлсэн 15,234,677,184 төгрөгийг өөрийн банкны дансанд хүлээн авсан болно.<br>Үүнээс хойш хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу 4,116,812,809 төгрөгийг түүхий эд материал (ТЭМ) худалдан авахад, 3,500,000,000 төгрөгийг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж худалдан авах урьдчилгаа төлбөрт тус тус зарцуулаад байна.<br>Компани 2024 оны 08 сарын 28-ныөдөр 6,003,000,000 төгрөгийг "Инвескор Эй Би Эс ТЗК" ХХК-ийн гаргасан ICAB BD ХБҮЦ (Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас)-д 6 сар хүртэлх хугацаатай байршуулсан.<br>IPO татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтанд тусгасан цахилгааны Трансформатор худалдан |

| | |
|---|---|
| | авах 550,000,000 төгрөгийн төлбөрийг 2024 оны 10 сарын 17-ны өдөр хуваарилсан.<br>Мөн 2024 оны 10 сарын 17-ны өдөр үйлдвэрийн шугамын тоног төхөөрөмж худалдан авах үлдэгдэл төлбөр 1,000,000,000 төгрөгийг хуваарилсан.<br>IPO татан төвлөрүүлсэн хөрөнгийн үлдэгдэл төлбөр болох 70,133,314.88 төгрөг нь компанийн дансанд байршиж байна.<br><br> |
| *9.* | *Ногдол ашгийн мэдээлэл* |
| | Эм Жи Эл Акуа ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2025 оны 2 сарын 12-ны өдөр хуралдаж, 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгийн дүнгийн 70 хувь буюу 2,393,776,441.73 төгрөгийг ногдол ашиг болгон хуваарилахаар шийдвэрлэв.<br>Хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд 7.31 (долоон төгрөг гучин нэгэн мөнгө) төгрөгийн ногдол ашгийг хуваарилна.<br>Ногдол ашиг хүртэх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөр тогтоож, ногдол ашгийг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор нийт хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулна.<br><br> |
| *10.* | *Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл* |
| | **БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА**<br><br>Эм Жи Эл Акуа ХК бизнесийн үйл ажиллагаагаа НҮБ-ийн тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудтай уялдуулан байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.<br>2024 онд жижиг хуванцар савны жин бууруулалтыг хийж **28,282 кг** хуванцрын хэмнэлтийг бий |

болгов.
Тайлант онд бид байгаль орчинд үзүүлж буй нөлөөллөө тооцохоор хүлэмжийн хийн ялгарлын тооллогыг хийлгэв.




Эм Жи Эл Акуа ХК нь үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг зориулалтын дагуу дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлдэг. 2024 онд хаягдал гялгар 8.9 тонн, хаягдал хуванцар 8 тонныг дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэв.




“Байртай бөглөө” хөтөлбөрөөр дамжуулан уусан усныхаа бөглөөг цуглуулах зорилгод хэрэглэгчдийг нэгтгэж хуванцар бөглөө байгальд хаягдахаас урьдчилан сэргийлж, 1.3 тонн бөглөө буцаан цуглуулан хэрэглэгчдийг хуванцар хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулалтад хувь нэмэр оруулахыг уриалав.
Түүнчлэн тус хөтөлбөрийн супер бэлгийн хоёр азтан тус бүрт хоёр өрөө байр бэлэглэж, агаарын бохирдлын эсрэг хувь нэмрээ оруулахаар зорьсон.




## ОЛОН ТАЛТ БАЙДАЛ БА ХҮРТЭЭМЖТЭЙ АЖЛЫН БАЙР

БОНЗ-ын зарчмуудыг Эм Жи Эл Акуа ХК-ийн ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны, тусгай хэрэгцээтэй ажилтны хөдөлмөр эрхлэлтийн бодлогуудад жендер болон эрх тэгш байдал, хүртээмжит байдал, олон янзат байдлыг тусган хэрэгжүүлж байна. Тайлант онд 205 ажлын байрыг бий болгон, өрсөлдөхүйц цалин урамшууллыг бий болгож ажиллав. Тусгай хэрэгцээт иргэдийн эрх тэгш ажиллах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор онцлог, ялгаатай байдалд нь тохирсон ажлын байр бий болгоход анхаарч ажилладаг.




Компанийн ажилтнуудын эрүүл мэндэд анхаарал тавих үүднээс бид урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, бүх ажилтнуудаа эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. Энэ арга хэмжээ нь эрт илрүүлэгийн ач холбогдлыг ойлгуулж, ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилготой юм.





## СУРГАЛТ, ХӨГЖИЛ

Эм Жи Эл Акуа ХК алба бүрийн үйл ажиллагааны онцлогт тохируулсан сургалтын төлөвлөгөөг боловсруулж, ажилтны хөгжлийн тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд 31 удаагийн 2070 цагийн сургалтыг зохион байгуулжээ.




## ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тайлант онд 850 гаруй хайлаас, гацуур мод нэмж тарьж, усалгаа, арчилгааг хийлээ.







## ЭРҮҮЛ ИДЭВХТЭЙ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ

Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягыг бий болгох, дэмжих зорилгоор уул “Хамтдаа алхацгаая клуб НҮТББ”-н гишүүдийг БНХАУ, ӨМӨЗО, Далан хар уулын Монгол Хятад хоёр улсын анхдугаар хамтарсан алхалт хийхэд дэмжлэг үзүүлэв.






**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ**

Эм Жи Эл Акуа компани нь Монгол Улсын эрүүл мэндийн салбарын оюутан залуусыг олон талт боломжоор хангах, ирээдүйн чадварлаг мэргэжилтэнг бэлтгэх зорилгоор “Med Plus Эрүүл мэндийн мэргэжилтний хөгжлийн хурдасгуур НҮТББ”-тай хамтран ажиллаж байна.

Хамтын ажиллагааны хүрээнд эрүүл мэндийн чиглэлээр суралцаж буй оюутан залуус болон залуу эмч нарыг эрүүл мэндийн салбартаа түүчээлэх, мэргэжлийн үнэ цэнээ ойлгох, цаашид нарийн мэргэжил эзэмшин суралцахад чиглүүлэх болон тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломжуудыг нээн, оюутан байх хугацаандаа эзэмшвэл зохих дадал, хувь хүний төлөвшил, хандлагыг сайжруулахаар “Эрүүл мэндийн манлайллын хөтөлбөр”-ийг дэмжиж ажиллав.







**БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ**



Орон нутагт салбар үйлдвэр барих төслийн хүрээнд ТУЗ-аас охин компани байгуулах тогтоолыг 2024.11.29-ний өдөр гаргав.

Ти Эм Ал Акуа ХХК-ийг 2024.12.23-ны өдөр байгуулсан.

2024.12.25-нд төсөл хэрэгжүүлэх газрыг сонгон худалдан авалт хийгдлээ.

ТЭЗҮ-р төслийн нийт санхүүжилтийг 8.9 тэрбум тооцож, үүнээс 6 тэрбумыг олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөс, үлдэгдэл төлбөрийг зээлээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Х.Тэгшээ

Албан тушаал: “Эм жи эл акуа ХК” -ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг: ……………………………………..

(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 2025. 03. 31

Овог, нэр: Г.Намхайдорж

Албан тушаал: ТУЗ НБД

Гарын үсэг: ………………………………………..